



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчтэй хувьцаат  
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
хараат бус гишүүн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 05/9748 дугаартай албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Дагмидын Янжинсүрэнг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг хараат бус гишүүнд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ